



УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

Энх тайвны өргөн чөлөө 44, Улсын Их Дэлгүүр, VI давхар,
Ш/Х-751, Улаанбаатар 210644, Монгол Улс
Утас: (976-11)-319292, Факс: (976-11)-319393
E-mail: sds@nomin.net

2018 оны 04 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар...01

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ №01

Тооллогын комиссыг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60.2.9, 67 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 тоот тогтоол, 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны тайланг хэлэлцэх ээлжит хурлын үеэр ажиллан Монгол улсын Компанин тухай хуулийн 67-д заасан эрх үүргийг хэрэгжүүлэх Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг зөвшөөрсүгэй.
Тооллогын комиссын даргаар хуульч Н.Цагаанхүү
Тооллогын комиссын гишүүнээр хувьцаа эзэмшигч Б.Ганцэцэг
Тооллогын комиссын гишүүнээр "УИД" ХК-ийн нягтлан бодогч Д.Чимгээ
2. Тооллогын комисст ажиллах томилогдсон хүмүүс нь хурлын ирц, санал асуулгын дүнг хуульд заасны дагуу үнэн зөв нэгтгэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБАТ



УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

Энх тайвны өргөн чөлөө 44, Улсын Их Дэлгүүр, VI давхар,
Ш/Х-751, Улаанбаатар 210644, Монгол Улс
Утас: (976-11)-319292, Факс: (976-11)-319393
E-mail: sds@nomin.net

2018 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар...⁰²

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ №02

Компанийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлан, Аудитын хорооны дүгнэлт,
2018 оны ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62, 63 дугаар зүйл, хувьцаа
эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд
Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг
зөвшөөрсүгэй.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 20~~18~~¹⁷ оны зардлын төсвийг
хавсралт №01-ээр баталсугай.
4. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх төслийг хэрэгжүүлэхээс
татгалзсугай.
5. Компанийн өрийг хувьцаагаар солих төслийг хэрэгжүүлэхээс татгалзсугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБАТ